

Батлав. БОУАӨЯ-ны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга:

...../Г.Энхмөнх/

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн: Премиум Бьюлдинг Материалс ХХК-н

Гүйцэтгэх захирал:/А.Ганболд/



НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ 10 ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ БЕТОН
ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭР ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР: 6266258/

Хянасан:

БОУАӨЯ-ын Үнэлгээ, аудитын хэлтэсийн шинжээч/Н.Эрдэнэчимэг/

Боловсруулсан:

Премиум Бьюлдинг Материалс ХХК-ийн ХАБЭА,БО албаны менежер/Л.Энхбат/

Нэг. Төслийн товч танилцуулга

“Премиум Бьюлдинг Материалс” ХХК нь нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 -р хороо, Улиастайн гудамж 101/А тоотод “ZOOMLION-CIFA” NZS120P дугаар бүхий бүрэн автомат үйлдвэрийг 2017 оноос угсралт суурилуулалт хийн ашиглаж байгаа бөгөөд тухайн үйлдвэрлэл явуулж байгаа үйлдвэр нь орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон, үйлдвэрлэл явуулж байгаа бүс нь нэгдсэн харуул хамгаалалттай, ашиглаж байгаа зам талбай нь тусгайлан засаж бетон хучилт хийгдсэн түүхий эдийн агуулах талбай, явган болон авто зам, тэдгээрийн гэрэлтүүлэг, машин техникийн угаалгын хэсэг зэрэг нь дэлхийн жишигт нийцсэн үйлдвэрийн бүрдэл хэсгүүд юм.



Хоёр. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

Баянзүрх дүүргийн 10 -р хороо, Улиастайн гудамж 101/А тоотод “ZOOMLION-CIFA” NZS120P дугаар бүхий бүрэн автомат үйлдвэрийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тодотгол тайланг 2022 онд “Эм И Эс Зэт Би” ХХК -р хийж гүйцэтгүүлсэн бөгөөд тус матрицын үнэлгээний арга дээр тулгуурлан Олон улсын туршлагад өргөн хэрэглэгдэж буй нөлөөллийн үнэлгээний үр дагавар болон тохиолдох магадлалын шалгуур үзүүлэлтүүдийн ашиглан байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр ангилан хийж гүйцэтгэсэн. Тус тайланд бетон зуурмагийн үйлдвэр нь өөрийн эзэмшлийн талбайд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд үйлдвэрийн талбай нь бүрэн хатуу хучилттай, төслийн хүрээнд ямар нэгэн барилга угсралтын үйл ажиллагаа нэмж явагдаагүй тул хөрсөн бүрхэвч болон ургамлын нөмрөгт аливаа сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй. Үүний дээр бетон зуурмагийн үйлдвэр нь Улаанбаатар хотын аж үйлдвэрийн бүсэд орших ба үйлдвэрийн ахуйн бохир усаа стандартын дагуу газар доор төмөр савд цуглуулан зориулалтын техникээр соруулдаг тул зэрлэг ан амьтан болон усан орчинд үзүүлэх сөрөг

нөлөөлөл байхгүй.

Бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагааны онцлогоос харахад уг үйлдвэр нь нийгэм-эдийн засагт эерэг нөлөөллүүд үзүүлдэг байна. Орчин үеийн стандартад нийцсэн, хэрэгцээнд түшиглэсэн бетон зуурмагийн үйлдвэр үйл ажиллагаа явуулснаар хэрэглэгчдэд чанартай бетон зуурмагаар хангагдах цаашлаад улс орны хөгжил, бүтээн байгуулалтанд эерэг нөлөөг үзүүлнэ.

Гурав. Төслийн гол ба сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл нь түүхий эдийг бункерт зөөж хийх үед тоосжилт үүсэх, ачигч болон миксер бүхий тээврийн хэрэгслээс ялгарах хорт утаа ялгарах, химийн бодисын хадгалалт, ашиглалтын явцад ууршимтгай дэгдэмхий нэгдлүүд агаарт уурших, асгарч болох зэргээр үйлдвэрийн гадаад орчны агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлэх, үйлдвэрийн гадаад орчны агаарын чанар муудсанаар ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, мөн үйлдвэрийн ажилчдын авто машин болон үйлдвэрт ашиглах химийн бодис, ачигч болон миксер бүхий тээврийн хэрэгслээс хорт утаа ялгарч агаарын чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй.

Дөрөв. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө, зорилт

“Премиум Бьюлдинг Материалс” ХХК нь төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжүүлж буй нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага боломжит төвшинд байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, үүсэн бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд “Премиум Бьюлдинг Материалс” ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэгч тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хянан үзэж, шинэчлэн сайжруулна. Ингэхдээ байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулан мөрдлөг болгон ажиллана.

ЗОРИЛТ:

2026 онд Премиум Бьюлдинг Материалс ХХК нь бетон зуурмаг үйлдвэрлэх төсөлд дараах зорилтыг тавин ажиллана.

Үүнд:

- ISO 14001:2015 стандартын магадлан аудитыг үл тохиролгүй шалгуур үзүүлэлтийг хангах
- Бетон зуурмагт ашиглах **үнс** /fly ash/ -ний хэрэглээг нэмэгдүүлэх.
- Үйл ажиллагаанаас гарах бетон зуурмагийн хаягдлыг багасгах, бетон эдлэл хийх.
- Технологийн тээврийн хэрэгсэл угаах, зам талбай усалгаа хийх саарал усны хэрэглээг нэмэгдүүлэх.
- Орчны тоосжилтыг бууруулах, тоосжилтоос сэргийлэх
- Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд үргэлжлүүлэн оролцож, тоог нэмэгдүүлэх

- Хог хаягдлын ангилан ялгалт болон менежментийг сайжруулах, мэдээлэл сургалтыг тогтмол өгөх

Тав. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанар, хөрсөн бүрхэвч болон усан орчин зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нь авч үзэн 2064 оны БОМТ-ний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Хүснэгт 1-д тусгав. Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд 2022-2026 ондууд 33923000 төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн. 2026 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд нийт 7820600 төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

Бид үйл ажиллагаандаа дахин боловсруулах, дахин ашиглах, ногоон худалдан авалтыг дэмжих шаардлагыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд усыг дахин ашиглах, хаягдал бетонийг дахин ашиглалтыг сайжруулсанаар үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ихэнд ажлыг өөрийн дотоод нөөцийг ашиглаж хэрэгжүүлэх боломж бүрдэж байна.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгалаа.

Хүснэгт 1. Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, төлөвлөгөө

№	Үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
Агаар									
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Химийн бодисын буруу хадгалалт, ашиглалтаас үүдэн химийн бодис ууршин агаарын чанарт сөргөөр нөлөөлөх, Хог хаягдлыг тээвэрлэхгүй удах зэргээр агаарын чанарт нөлөөлөл үүсэх	Хог хаягдлыг сар бүр тээвэрлэн зайлуулж байх /химийн болисын сав баглаа боодлын хаягдлыг журмын дагуу усгтгах/	Үйлдвэрийн талбай	Удаа	53,300	12	640,000	Сар бүр	“Агаарын тухай” болон “Агаарын бохирдлын төлбөрийн тухай” хууль/2012.05.17/ MNS 0017-2-3-16:1998 (Суурьшилын хэсгүүдэд) MNS 4585:2007 Агаарын чанар.Техникийн ерөнхий шаардлага Агааарын тухай хууль 21.1, 29.1 Байгаль орчныг хамгаалах тухай хууль 21.3
2		Химийн бодис, материалын хадгалалтын нөхцлийн стандартыг нарийн баримтлаж уурших, халах, тэлэх нөхцөлөөс бүрэн сэргийлэж ажиллах	Үйлдвэрийн талбай	-	-	-	-	Агуулахад химийн бодис хадгалах бүх үед	

3	Дайрганы үйлдвэрт хэрэглэгдэх түүхий эд /Дайрга, хайрга/ хадгалах, хураах талбайгаас салхиар дамжин агаарт тоосжилт үүсэх	Элс хайрга хадгалах талбайд хаалт, хамгаалалт хийх, эвдэрсэн бол сэргээн засварлах	Түүхий эд хадгалах, хураах талбай	М²	-	24637	Байгууллагын үйл ажиллагааны дотоод зардалд тусгасан	Тухай бүрт	Агаарын тухай болон агаарын бохирдлын хууль /2012.05.17/ MNS 0017-2-3-16:1998 “Агаарын бохирдлын төлбөрийн тухай” хууль/2012.05.17/ MNS 0017-2-3-16:1998
4	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг тусгайлан бэлдсэн цэгт хаяагүй, тогтсон хугацаанд ачуулж, ариутгал хийгдээгүйгээс орчны агаар бохирдох	-Дүүргийн ТҮК-тэй гэрээг сунгах, тогтмол хугацаанд хогоо ачуулах. - Хогийн цэгийг тогтмол хугацаанд хлорминаар ариутгах	Үйлдвэрийн талбай болон ойр орчимд	Удаа	95,000	12	1,140,000	Сар бүр	“Агаарын бохирдлын төлбөрийн тухай” хууль/2012.05.17/ MNS 0017-2-3-16:1998
5	Төслийн үйл ажиллагаанд ашигладаг тээврийн хэрэгслүүдээс агаар орчин бохирдох	Тээврийн хэрэгслүүдийг тогтмол үзлэг, оношлогоонд хамруулж, утаанд хяналт тавьж ажиллах, засвар үйлчилгээг тогтмол хийж байх.	Төслийн үйл ажиллагаанд ашигладаг тээврийн хэрэгслүүд	Ширхэг	Байгууллагын үйл ажиллагааны дотоод зардалд тусгасан	3	Байгууллагын үйл ажиллагааны дотоод зардалд тусгасан	Жил бүр	“Агаарын тухай” болон “Агаарын бохирдлын төлбөрийн тухай” хууль /2012.05.17/ MNS 0017-2-3-16:1998

Хүснэгт 1. Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, төлөвлөгөө /үргэлжлэл/

№	Үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
Гадаргын болон гүний ус									
	1	2	3	4	5	6	7	8	9
6	Гүний ус бохирдох	- Худгийн ойр орчимд анхааруулга самбар хадаж хог хаягдал, элдэв химийн бодис асгахгүй байхыг анхааруулах - Мөн худгаас ус зөөвөрлөдөг машин техникийн бүрэн бүтэн байдлыг байнга хянаж шатах тослох материал асгарахаас сэргийлэх - Гүний худгийн эргэн тойронд эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох - Үерийн уснаас хамгаалах хөмсөг хийх	Гүний худгийн ойр орчимд	Метр	10000	12	120,000	Жилд 1 удаа	“Усны тухай” хууль/2012.05.17/ Усны нөөцийг бохирдлоос хамгаалах дүрэм. БО болон ЭМ-ийн сайд нарын хамтарсан тушаал 167/335/A171 MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. MNS 3342:1982 Газрын доорх усыг бохирдлоос хамгаалах

7	Гүний усыг хэт их ашиглах, замбараагүй хэрэглэснээр гүний ус шавхагдах	• Гүний худагт хэмжилзүйн байгууллагаар баталгаажсан тоолуур суурилуулах • Ус ашиглах гэрээг сунгах	Гүний худаг	Ширхэг	50,000	1	50,000	Ээвдэрч гэмтсэн тохиолдолд
---	--	---	-------------	--------	--------	---	--------	----------------------------

Хүснэгт 1. Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, төлөвлөгөө /үргэлжлэл/

№	Үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
Хөрсөн бүрхэвч									
	1	2	3	4	5	6	7	8	9
8	Шатах тослох материал асгарснаар хөрсөн бүрхэвч бохирдох	•Хаягдал бетоноор хөрсөн бүрхэвчийг хамгаалах, бетон талбайг нэмэгдүүлэх	Засварын газар болон машин зогсоолын талбай	М³	-	50	Хаягдал буцаагдсан бетон ашиглах	6-р сард / 1удаа/ 9-р сард /1 удаа/ Нийт 2 удаа	MNS5914:2003 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008 (MNS 4918: 2000 болон MNS 4919 : 2000 -ын оронд). MNS5850-2008, “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
9	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлаас хөрсөн бүрхэвч бохирдох	Хогийн цэгийг засварлах, арчилах	Төсөл хэрэгжих талбайд	Ширхэг	1,000,000	1	1,000,000	7-р сард 1 удаа	
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙТ ЗАРДАЛ							2,410,000₮		

6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 онд өмнөх оны адил үйлдвэрлэлийн бүсийнхээ ногоон байгууламж, мод бут сөөгийг арчлах, зүлэг, цэцэгийг арчлах ажилууд хийхээр төлөвлөж байна.

Мөн “Олон улсын Эко цэцэрлэгт хүрээлэн”-нд 100 мод тарьж, Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд хувь нэмрээ оруулах болно.

Хүснэгт 2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
	1	2	3	4	5	6	7	8
1	Газрын гадаргыг механик эвдрэлээс сэргийлэх	Ногоон байгууламжийн арчилгаа хийлгэх, таналт тайралт, бордох	Үйлдвэрийн талбай	Удаа	2	350,000	700,000	5-сард 1 удаа 8-р сард 1 удаа Нийт 2 удаа
2	Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Мод тарих	Олон улсын цэцэрлэгт хүрээлэн	Ширхэг	100	20,000	2,000,000	2026 оны 5-р сарын 16 өдөр 1 удаа
2026 оны Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн нийт зардал						2,700,000₮		

7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Бетон зуурмагийн үйлдвэр нь төв суурин бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд, хүн амын суурьшилт бий болоод удаж байгаа ба энэ хугацаанд аливаа түүх, соёлын дурсгалт зүйлс, эртний олдворууд олдсон тохиолдол байхгүй тул энэ талаар мөн тусгагдаагүй болно. Болзошгүй зардалд 300,000 төгрөг төсөвлөсөн.

8. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 3. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Химийн бодис их хэмжээгээр асгарвал аюултай нөхцөл байдал үүснэ.	Болзошгүй тохиолдлоор химийн бодис асгарсан тохиолдолд хэрэглэх шохой, элс, шороог ажлын талбарт бэлэн байлгах	Үйлдвэрлэлийн талбай	1	100,000	100,000	4-р сард 1 удаа	<i>Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн А/356/396 дугаар хамтарсан тушаал</i> Химийн хорт болон аюултай бодисын ангиллыг ашиглах аргачлал
2		Химийн бодисын асгаралт, алдагдлаас сэргийлэх, асгаралтын хариу арга хэмжээний журам хэрэгжүүлэх	Нийт ажилчид	-	Үйл ажиллагааны зардалд тусгасан		3-р сард нийт ажилтны ХАБ-н сургалтыг зохион байгуулах, журмыг танилцуулах 1 удаа	ХАБЭА тухай хууль ХАБЭА сургалт зохион байгуулах, шалгалт авах журам
3	Хөдөлмөр хамгааллын дүрэм алдагдаж, ажиллагсад хамгаалах хэрэгслээ бүрэн ашиглаагүйгээс химийн бодисын нөлөөнд өртөнө	Химийн бодистой зөв харьцах, хадгалах, ашиглах талаар үйлдвэрийн ажилчдад сургалт зохион байгуулах	Химийн бодистой харьцаж ажилладаг нийт ажилчид	8 цаг	35,000	280,000₮	3-р сард сургалтыг зохион байгуулах 1 удаа	Химийн бодистой харьцаж ажилладаг ажилтанд олгох хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүний жагсаалт
4		Ажиллагсдыг эмнэлгийн үзлэг хамруулах	Нийт ажилчид	-	-	Үйл ажиллагааны зардалд тусгасан	3-р сард 1 удаа	
5		Ажилчдад хүнсний чанарлаг	БЗД-н үйлдвэрийн	-	-	Үйл	Өдөр бүр	

		бүтээгдэхүүн олгож байх / сүү, аарц, тараг/	ажилчид			ажиллагааны зардалд тусгасан		
6		Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах				Үйл ажиллагааны зардалд тусгасан	Өдөр бүр	
7	Байгалийн гамшигт үзэгдэлд нэрвэгдэх	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг ОБХ-р батлуулах, дадлага сургуулилт хийх БЗД-н ОБХэлтэстэй хамтран сургалт дадлага хийх	БЗД-н үйлдвэрийн ажилчид	-	-	Гамшгийн бэлэн байдлын зардалд тусгасан	7-р сард 1 удаа	Гамшгаас хамгаалах тухай хууль ХАБЭА тухай хууль Гамшгаас хамгаалах төлөвлөгөө
2026 оны Осол, эрсдлийн менежментийн зардал – Нийт						380,000		

8.2. Химийн бодис эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 4. Химийн бодис эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Эрсдэл тохиолдсон үед авах арга хэмжээ	Эрсдэл тохиолдсоны дараа авах арга хэмжээ	Баримтлах стандарт, аргачлал
1. Химийн бодисын тээвэрлэлтийн үед байгаль орчинд үзүүлэх эрсдэл				
Химийн бодис ачих, буулгах, зөөх явцад бодис асгарах, сав баглаа боодол задрах.	Баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг шалгах, химийн бодисыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх, ачилт,буулгалтыг техникээр гүйцэтгэх	Химийн бодис асгарсан тохиолдолд нэмж газар авахуулахгүй байх арга хэмжээ авч цэвэрлэх,	Химийн бодисын сав баглаа боодлыг гэмтээж асгаралт үүсгэсэн шалтгааныг илрүүлж, арилгах	Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам. БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайд, ОБЕГ-ын даргын 28/40/29 дүгээр хамтарсан
Тээвэрлэлтийн явцад химийн бодис гээгдэх, тоо ширхэг дутах, цас борооны устай урвалд орж асгарснаас байгаль орчныг бохирдуулах, агаарт дэгдэх, тоосжилт үүсэх	Химийн бодисыг гээгдэж хаягдахгүйгээр, норох агаарт дэгдэхээс сэргийлсэн хучлага бүтээлгэтэйгээр тээвэрлэх, тоо ширхэг, нэр төрлийг бүртгэн авч хүлээлцэх,химийн бодис тээвэрлэх үеийн аюулгүй	Тээвэрлэлтийн явцад химийн бодис дутсан тохиолдолд эрлийн баг гаргах, нийслэл, дүүргийн цагдаа онцгой байдлын газарт мэдэгдэх.	Тухайн химийн бодис, тээврийн хэрэгслийг хариуцсан эзэнд хариуцлага тооцох, хүн болон байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулах	“Агаарын тухай” болон “Агаарын бохирдлын төлбөрийн тухай” хууль /2012.05.17/ MNS 0017-2-3-16:1998 (суурьшлын хэсгүүдэд) MNS4585:2007 Агаарын чанар.

ажиллагааг хангаж ажиллах				Техникийн ерөнхий шаардлага
2. Химийн бодисын хадгалалтын үед байгаль орчинд үзүүлэх эрсдэл				
Агуулахаас химийн бодис алдагдах	Химийн бодисыг хадгалах үеийн савны битүүмжлэл, бүрэн бүтэн байдлыг байнга шалгах, Химийн бодисыг хадгалах агуулахын үерийн хамгаалалт, шал суурийг шингэн үл нэвчүүлэх материалаар хийх,	Химийн бодис асгарсан тохиолдолд нэмж газар авахуулахгүй байх, хязгаарлах, тусгаарлах арга хэмжээг авч, цэвэрлэх,	Химийн бодисыг хадгалах, агуулах болон барилга байгууламжийн үерийн хамгаалалт, даланг зураг төслийн дагуу барих, тэдгээрийн шал суурийг шингэн үл нэвчүүлэх материалаар хийх,	Байгаль орчныг хамгаалах тухай хууль /2012.05.17/ Монгол улсын стандартууд, MNS4226:2000 Агаар орчны чанарын үзүүлэлт
Хадгалалтын явцад гал, үерийн усны аюул тохиолдох	Химийн бодисыг халаалтын хэрэгсэл, системээс хол, шууд нарны гэрэл тусахааргүй, үерийн усанд автахааргүй нөхцөлд хадгалах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байршуулах	Гал унтраах ажиллагаанд бэлэн байх, үерийн усыг шавхан зайлуулах Гал болон үерт өртсөн химийн бодисыг ялган тусад нь хадгалж устгах	Галын дүгнэлтийг гаргуулж гамшгаас хамгаалах төлөвлөгөөг гарган БЗД-н Онцгой байдлын хэлтэсээр батлуулан мөрдөж ажиллах	Гамшгаас хамгаалах тухай хууль Галын аюулгүй байдлын тухай хууль Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
3. Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын үед хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдэл, Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа				
Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт ашиглалтын үед ажиллах хариуцсан ажилтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Химийн хорт болон аюултай бодистой харьцаж байгаа ажилтанг хамгаалалтын шил, резинэн бээлийгээр хангах, маск хэрэглэх	Ажлын дараа биеийн бохирдсон хэсгийг угаах Бохирдсон бээлий, нэг удаагийн ковралыг зориулалтын хогийн саванд хийх	Асгаралтын үед ажиллах журмыг дагаж мөрдөх Химийн хортой аюултай бодистой ажиллах мэдлэгийг ажилтанд өгөх Хамгаалах хувцас хэрэглэлээр хангах	Химийн хортой аюултай бодис ын тухай хууль Асгаралтын хариу арга хэмжээ авах журам Химийн хортой, аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах устгах тухай журам БОАЖ-н сайд, ЭМ- ийн сайд, ОБЕГ-н даргын 28/40/29 дүгээр хамтарсан тушаал, 2009

Тохиолдсон эрсдэлийг устгах, нөлөөллийг бууруулах арга авах	Асгаралты үүсэх орчинд Асгаралтын иж бүрдэл байршуулах Эрүүл мэндийн үзлэгт ажилчдаа тогтмол хамруулах; Химийн бодистой анхаарал болгоомжтой ажиллах, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Бохирдсон хэсгүүдийг байнга цэвэр байлгах	Анхны тусламжийн хэрэгсэлийг ажлын байранд байршуулах	
--	---	---	--	--

9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Бид 2025 онд Хог хаягдлын менежментийг сайжруулж, үйлдвэрлэлээс болон хүний үйл ажиллагаанаас гарч болох бүхийл хаягдлыг бүртгэлжүүлэн, дата файл үүсгэж байна. Ингэснээр 2026 оноос эхлэн цуглуулсан датаг ашиглан Байгаль орчны үйл ажиллагааны зорилтоо хэмжигдэхүйцээр тавьх боломжийг бүрдүүлсэн. Тус онд бид хог хаягдлын менежментийг сайжруулах, орчны бохирдлоос сэргийлэх 5 ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн	Ахуйн хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлнэ. Хог хаягдлын бүртгэл хөтлөж явна.	Үйлдвэрийн бүс	Тонн	Байгууллагын үйл ажиллагааны дотоод зардалд тусган хэрэгжүүлнэ	-	Байгууллагын үйл ажиллагааны дотоод зардалд тусган хэрэгжүүлнэ	Сар бүр	MNS5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ хууль АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ТҮР ХАДГАЛАХ, ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ БОЛОН БҮРТГЭХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ
2		Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр. гал тогоонд хортон шавьжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх	Үйлдвэрийн бүс	Удаа	166,000	3	500,000	6-р сард 1 удаа 7-р сард 1 удаа 8-р сард 1 удаа	
3		Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх. задлах бодис худалдаж авах зардал	Үйлдвэрийн бүс	литр	18,000	10	180,000	5-р сард	
4	Үйлдвэрийн	Хаягдал бетоныг ашиглах, блок хийх Хог хаягдлын бүртгэл хөтлөж явна.	Үйлдвэрийн бүс	Тонн	Байгууллагын үйл ажиллагааны дотоод зардалд		Байгууллагын үйл ажиллагааны дотоод зардалд	Сар бүр	

					тусган хэрэгжүүлнэ		тусган хэрэгжүүлнэ		
5	Аюултай	Үйлдвэрийн засварын цехээс гарах ашигласан тос маслыг “Элемент ХХК”-д шилжүүлнэ. Хог хаягдлын бүртгэл хөтлөж явна.	Үйлдвэрийн бүс	Литр	Байгууллагын үйл ажиллагааны дотоод зардалд тусган хэрэгжүүлнэ	-	Байгууллагын үйл ажиллагааны дотоод зардалд тусган хэрэгжүүлнэ	Тухай бүрт	
2026 оны Хог хаягдлын менежментийн нийт зардал							680,000		

10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
1	Хөрсний механик бүрэлдэхүүн	Төсөл хэрэгжих талбай 107°1'20.042" 47°54'48.161" 107°1'21.306" 47°54'47.995"	5 сарын 15нд 9 сарын 15нд	2 /нэг удаад 2 дээж/	20,000	80,000	Хөрсний үе давхаргын зузаан (см), элэгдэл эвдрэлийн нөхцөл, ялзмаг %, pH, давсжилт, чийгшилт, Pb, As, Cd, Hg, Cu –ийн агууламж Физик шинж чанар, органик бодис, нийт азот, карбонат, Ca, Mg, P ₂ O ₅ , K ₂ O, хөрсний pH, Pb, Cd, As, Zn, Ce –ийн агууламж	– MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл – MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох – MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам – MNS(ISO)4814:1999. Атом
2	Хөрсний агрохимийн найрлага	Төсөл хэрэгжих талбай 107°1'20.042" 47°54'48.161" 107°1'21.306" 47°54'47.995"	5 сарын 15нд 9 сарын 15нд	2 /нэг удаад 2 дээж/	20,000	80,000		Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх
3	Хөрсөн дэх пестицид, гербицидийн үлдэгдэл	Төсөл хэрэгжих талбай 107°1'20.042" 47°54'48.161" 107°1'21.306" 47°54'47.995"	5 сарын 15нд 9 сарын 15нд	2 /нэг удаад 2 дээж/	25,000	100,000		
4	Агаарын чанар	Ажлын байранд, үйлдвэрийн талбайн ойр орчимд 107°1'19.967" 47°54'48.63" 107°1'17.868" 47°54'47.256"	Жилд 2 удаа, 2 цэгээс. 5 сард, 9 сард	2	24 цагийн хэмжилт хийж (O ₂ , SO ₂ , NO ₂ , CO , цаг агаарын үзүүлэлт)-ийг хамт тооцоход	500,000		–MNS3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага – MNS0017-2-3-16:1988. Агаар мандал- Хот, суурингийн агаарын

					250.0 мян.төг			бохирдлын шинжилгээ – MNS3384:1982. Агаар мандал- Агаарын дээжилт шинжилгээ –MNS3113:1981. Хорт утааны ялгаралтыг хэмжих арга – MNS5061:2001. Нүүрс хүчлийн хий- CO2 тодорхойлох эзэлхүүний арга – MNS0012-014:1991. Ажлын байрны агаар- Бичил орчинг шинжлэх арга
5	Усан орчин Бактериолог ийн бүрэн шинжилгээ, хүнд металлын шинжилгээг хийлгэх.	Гүний 1 худгаас 107°1'18.77" 47°54'47.17"	5 сарын 15нд 9 сарын 15нд	2 удаа	Усны 23 элемент хүнд металлын шинжилгээ бохир ус-78,3 мян.төг Хими бактериологийн бүрэн шинжилгээний үнэ 217,0 мян.төг	590,600	Усны pH, цахилгаан дамжуулах чадвар нүүрстөрөгчийн исэл CO ₃ , хүчил HCO ₃ , кальци Ca, хлор Cl, кали K, магни Mg, сод Na, хүхэр S, хүнцэл As, бор B, бари Ba, кадми Cd, кобальт Co, хром Cr, зэс Cu, төмөр Fe, мөнгөн ус Hg, манган Mn, молибден Mo, никель Ni, хар тугалга Pb, селени Se, силиконSi, ванади V, цинк	– MNS0900:2005 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ – MNS3935:1986 Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага – MNS3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус- Тухайн талбарт нь шинжилгээ хийх – MNS4432:1997 Ундны ус-Хуурай үлдэгдлийн хэмжээг тодорхойлох – MNS3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус- Химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх – MNS5667-10:2001 Усны чанар-Дээж авах- 2-р бүлэг. Хаягдал

							Zn, хөнгөн цагаан Al, мөнгө Ag, Хими бактериологийн бүрэн шинжилгээ	уснаас дээж авах – MNS5667-2:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг Дээж авах арга – MNS4867:1999 Усны чанар-Дээж авах-3-р бүлэг Авсан дээжийг зөөвөрлөх, хадгалах арга
	Нийт					1,350,600		

11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг үйлдвэрийн дарга, менежерүүд болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилчид, болон байгаль орчны мэргэжилтэнгүүд хариуцан ажиллана.

Хүснэгт 7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			Сар 1-3	Сар 4-6	Сар 7-9		
	1	2	3	4	5	6	7
1	Ус ашиглах дүгнэлт гаргуулах	-	*			Байгаль орчны ажилтан	1-р сард багтаан холбогдох материалыг бүрдүүлэх
2	Хаягдал усны дүгнэлт гаргуулах	-	*			Байгаль орчны ажилтан	1-р сард багтаан холбогдох материалыг бүрдүүлэх
3	Ус ашиглах гэрээ байгуулах	-	*			Байгаль орчны ажилтан	1-р сард багтаан холбогдох материалыг бүрдүүлэх НБОГ-тай гэрээ байгуулах
4	Хог хаягдлын гэрээ байгуулах	-		*		Байгаль орчны ажилтан Худалдан авалтын ажилтан	БЗД-н тохижилт үйлчилгээний газартай гэрээ байгуулах
5	Аюултай хог хаягдлын гэрээг сунгах	-		*		Байгаль орчны ажилтан Худалдан авалтын ажилтан	Элемент ХХК-тай байгуулсан гэрээг сунгах
6	БЗД-н ОБХэлтэстэй хамтран гамшгийн бэлэн байдлын сургалт, дадлага хийх	-			*	ХАБЭА ажилтан Үйлдвэрийн менежер, захирал	БЗД-н ОБХэлтэс, Гал унтраах ангитай хамтарч ажиллах, төлөвлөгөөг батлуулах
7	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сургалт сурталчилгааны самбар гаргаж, шинэчилж байх	Дотоод үйл ажиллагааны зардал	*		*	ХАБЭА ажилтан	Агуулгыг шинэчлэх, нийт ажилчдад мэдээлэх
8	Байгаль орчныг ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, сургалтын агуулгыг сайжруулан, самбар бэлтгэх	Дотоод үйл ажиллагааны зардал	*		*	ХАБЭА ажилтан Байгаль орчны ажилтан	Агуулгыг шинэчлэх, нийт ажилчдад мэдээлэх

9	Усны алдагдлыг бууруулж, хэмнэлтийн баг үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, шийдлээр хэрэглээг багасган ажиллах	Дотоод үйл ажиллагааны зардал	*	*	*	Үйлдвэрийн менежер Технологийн инженер БО ажилтан	Нийт ажилчдад мэдлэг ойлголт өгөх, усны хэрэглээний холбогдох бүртгэлийг хөтлөх, хянах
10	Дулаан цахилгааны алдагдлыг бууруулж, хэмнэлтийн баг үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, шийдлээр хэрэглээг багасган ажиллах	Дотоод үйл ажиллагааны зардал	*	*	*	Үйлдвэрийн менежер Технологийн инженер Цахилгаанчин	
11	Галын аюулаас хамгаалах анхааруулга санамж, зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг хийж тавих	Дотоод үйл ажиллагааны зардал	*			ХАБЭА ажилтан	Тэмдэг, тэмдэглэгээ болон анхааруулах, сануулах тэмдэгийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, агуулга, үзэгдэх байдлыг шинэчлэх
12	эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолууд зохих газар нь байнга бэлэн байлгах		*	*	*	ХАБЭА ажилтан	Анхны тусламжийн хайрцагны бүрэн бүтэн байдлыг шалгах, бүртгэлийн хуудсыг хөтлөх
	Нийт	-					

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ
НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Биелэлтийг тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Хорооны иргэдийн төлөөлөл	Тайлагнах, хэлэлцүүлэх	2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан	2026 оны 11 сар	Компанийн үйл ажиллагааны зардалд тусгасан	Үйлдвэрийн захирал, менежерүүд Маркетингийн алба ХАБЭА, БО алба	Үйлдвэрийн хурлын заал Компанийн веб
2	БЗД-н БО асуудал хариуцсан ажилтан	Тайлагнах	2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан	2026 оны 12 сар	-	ХАБЭА, БО албаны ажилчид	БЗД-н тамгын газар
3	Нийслэлийн Байгаль орчны газар	Тайлагнах	2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан	2026 оны 12 сар	-	ХАБЭА, БО албаны ажилчид	НБОГ-н байр
4	Туул голын сав газрын захиргаа	Тайлагнах	2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан	2026 оны 12 сар	-	ХАБЭА, БО албаны ажилчид	Усны газар
5	БАУАӨЯам	Тайлагнах	2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан	2026 оны 12 сар	-	ХАБЭА, БО албаны ажилчид	Яамны сайтад тайланг оруулах
	Нийт				-		

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2026 оны төсөв:

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2026 онд 7,820,600 төгрөгийг тусгаснаас сөрөг нөлөөллийг бууруулах арилгах, ногоон байгууламж нэмэгдүүлэх арчлах арга хэмжээний зардалд нийт 5,110,000 төгрөг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 1,350,600 төгрөгийг төсөвлөлөө.

Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2026 оны хүснэгт

Д.д	Зардлын утга	Төсөв. Мян төг
1	Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	2,410,000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зардал	2,700,000
3	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд тусгасан зардал	380,000
4	Хог хаягдлын менежментээр хийгдэх ажлын зардал	680,000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1,350,600
6	Түүх соёл шинжлэх ухааны дурсгалт зүйлд зарцуулах болзошгүй зардал	300,000
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн /мян.төгрөг/		7,820,600